



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ТОЙМ ДҮГНЭЛТ

Хэлэлцүүлэгт зориулсан тойм

2016 ОНЫ 3-Р УЛИРЛЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БА ТОДОТГОЛ

ЭРҮҮЛ МЭНД БА БСШУС-ЫН САЙДЫН 2012-2017 ОНЫ ТӨСВИЙН
ЗАРЦУУЛАЛТЫН ЧИГ ХАНДЛАГА




ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

БСШУС-ЫН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТОЙМ ДҮГНЭЛТ БА БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

2016 оны 9-р сарын байдлаар Эрүүл, мэндийн салбарын зардлын гүйцэтгэл 92.4%, Боловсролын салбарын гүйцэтгэл 81%-тай байна.

[%] Гүйцэтгэл хувь %




2016 оны 9-р сарын байдлаарх Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг салбараар авч үзвэл эрүүл мэндийн салбар 92.4%, боловсролын салбар 81%-ийн гүйцэтгэлтэй байна. Харин хөтөлбөрөөр авч үзвэл эрүүл мэндийн хөтөлбөр 89.6%, боловсрол, шинжлэх ухааны хөтөлбөр 84.4%-ийн гүйцэтгэлтэй байна. Арга хэмжээгээр авч үзвэл эрүүл мэндийн арга хэмжээ 66.8%, боловсролын арга хэмжээ 86%-ийн гүйцэтгэлтэй байна.

Эх үүсвэр: Сангийн яам

2012-2017 оны чиг хандлагаар эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалтын жилийн дундаж өсөлт 8.6% байна.

2012-2017 оны эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалт

Тэрбум төгрөг



*ЖДӨ=8.6%


*ЖДӨ-Жилийн дундаж өсөлт (Average Annual Growth Rate)

Эх үүсвэр: Сангийн яам, Судлаачийн

2012-2017 оны чиг хандлагаар Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн зарцуулалтын жилийн дундаж өсөлт 8.3% байна.

2012-2017 оны БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалт

Тэрбум төгрөг



*ЖДӨ=8.3%


*ЖДӨ-Жилийн дундаж өсөлт (Average Annual Growth Rate)

Эх үүсвэр: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2012-2017 оны чиг хандлагаар нэг хүн амд ноогдох Эрүүл мэндийн сайд ба Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн зарцуулалтыг тооцвол өсөлтийн хурд харьцангуй бага байна.

2012-2017 оны Эрүүл мэнд, БСШУС-ын төсвийн зарцуулалт (1 хүн амд ноогдох)

мян төгрөг




- 1 хүнд ноогдох Эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалт (мян төг)
- 1 хүнд ноогдох Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын зарцуулалт (мян төг)

*2017 оны хүн амын тоог 2016 оны түвшнээс 1.8%-иар өснө гэж тооцоолон 1 хүнд ноогдох төсвийн зарцуулалтыг тооцсон болно.


Эх үүсвэр: Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Судлаачийн тооцоолол

Эрүүл мэндийн салбарын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь бусад улс орнуудтай харьцуулахад бага байгаа бол боловсролын салбарын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь бусад орнуудтай ойролцоо түвшинд байна.

Эрүүл мэндийн салбарын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь (харьцуулалт)



Боловсролын салбарын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь (харьцуулалт)



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам, Дэлхийн банк


*2015 оны үзүүлэлтийг харьцуулав. Дэлхийн банкны ангиллаар Монгол улс дунджаас доогуур орлоготой орны тоонд багтаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 онд эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд зарцуулах нийт урсгал зардлын хэмжээ өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад бага зэрэг өснө.

2017 оны Эрүүл мэндийн сайдын багцын эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн урсгал зардал

Тэрбум төгрөг



Тойм дүгнэлт

- Монгол улсын 2017 оны нэгдсэн төсөвт Эрүүл мэндийн сайдын багц дахь эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн нийт урсгал зардлын хэмжээг **573.5** тэрбум төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад **5.3%**-иар өсчээ.
- Үүнээс нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд **9.9%**, эмнэлэгийн тусламж үйлчилгээнд **82.1%**, эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрт **8.1%**-ийг тус тус зарцуулна.
- Өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн урсгал зардал **11.9%**-иар, эмнэлэгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн урсгал зардал **3.4%**-иар, эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн урсгал зардал **18.8%**-иар тус тус өсчээ.
- Нийт эрүүл мэндийн хөтөлбөрийн урсгал зардлыг төрлөөр нь авч үзвэл цалин, НДШ **41.5%**, бараа үйлчилгээ **33.9%**, татаас шилжүүлэг **24.6%**-ийг тус тус эзэлж байна.
- Нийт эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн урсгал зардлын **30.8%**-ийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

Эх үүсвэр: Сангийн яам

Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)

Өөрчлөлт %

Хувийн жин %

Өөрчлөлт %	Хувийн жин %
Эрүүл мэндийг дэмжих 67,6%	5.3%
Үндсэн үйл ажиллагааны зардал 18,3%	41.0%
Харуул хамгаалалтын зардал 6,1%	0.3%
Анхан шатны тусламж үйлчилгээний тусгай шилжүүлэг 4,9%	49.0%
Мэдээлэл зар сурталчилгааны зардал 0,0%	0.0%
Эмчилгээний төлбөр 0,0%	0.9%
Анхан шатны тусламж үйлчилгээ 0,0%	0.5%
Төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ 0,0%	2.5%
Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал 0,0%	0.1%
Зардал буурах [VALUE]	0.3%


Зардал өсөх

Зардал өөрчлөгдөхгүй


Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл эрүүл мэндийг дэмжих, үндсэн үйл ажиллагааны, харуул хамгаалалтын, анхан шатны тусламж үйлчилгээний тусгай шилжүүлгийн зардал тус тус өссөн бол ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардлууд нь анхан шатны тусламж үйлчилгээний зардал 49%, үндсэн үйл ажиллагааны зардал 41% байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн эрүүл мэндийн үр дүнгийн үзүүлэлтүүдэд төдийлөн өндөр ахиц гараагүй байна.


Түрхэц эерэг сүрьеэгийн тохиолдлын илрүүлэлт (хувь)




Хорт хавдар оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь



100000 хүн амд ногдох сүрьеэгийн шалтгаант нас баралтын түвшин



0-1 хүртлэх насны хүүхдийн дархлаажуулалтын хамралтын хувь




Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам, Сангийн яам

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)

Өөрчлөлт %

Хувийн жин %




Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамуулал, дэмжлэг, харуул хамгаалалтын зардал өндөр өсөлттэй байгаа бол эрүүл мэндийн үндэсний бусад хөтөлбөрүүдийн зардлыг бүрэн хассан байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардлууд нь үндсэн үйл ажиллагааны зардал 71%, тусгай зориулалтын шилжүүлэг 17.1% байна.

Сүүлийн жилүүдэд эхийн эндэгдлийн түвшин буурсан боловч нялхас ба 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буураагүй байна.

Хүүхэд ба эхийн эндэгдлийн түвшин




1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (харьцуулсан)



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам, Дэлхийн банк

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж харьцангуй тэгш бус байна.


Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд




5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд



Эхийн эндэгдэл, 10000 амьд төрөлтөд



Амьгүй төрөлт, 1000 төрөлтөд



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам, 2015 ойн үзүүлэлт

Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)

Өөрчлөлт %


Хувийн жин %




Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл эрүүл мэндийн уралдаан тэмцээн, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал өндөр өсөлттэй байгаа бол харуул, хамгаалалтын зардал, шүүхийн шийдвэрийн дагуу иргэдэд олгох төлбөр буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардлууд нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 62.4%, үндсэн үйл ажиллагааны зардал 35.3% байна.

10000 хүн амд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо 156 орчим байна.


10000 хүн амд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо



Гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмнэлгийн мэргэжилтний тоо



Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний тоо



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам, Сангийн яам

Хөдөө орон нутаг ба хот дахь эмнэлгийн мэргэжилтний тооны хүртээмж ялгаатай байна.

Аймаг, хот	10000 хүн амд					Эмнэлгийн оронд ногдох хүний тоо	Нэг их эмчид ногдох хүний тоо	Жилд нэг иргэний үзүүлсэн дундаж тоо
	Орны тоо	Хүний их эмч	Сувилагч	Эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтнууд	Бүх ажиллагсад			
Аймгийн дундаж	62.1	22.6	33.1	30.1	136.2	160.9	441.7	4
Улаанбаатар	83.2	42.3	42.8	17.9	181.2	120.1	236.5	7.3
Улсын дундаж	71.8	31.6	37.5	24.5	156.7	139.4	316.5	5.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам, 2015 оны үзүүлэлт


БСШУС-ЫН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 онд дээд боловсрол, насан туршийн албан бус боловсрол, боловсрол, ШУ-ны бодлого удирдлагын хөтөлбөрүүдийн урсгал зардлын хэмжээ буурна.

2017 оны БСШУС-ын сайдын багцын Боловсрол, шинжлэх ухааны хөтөлбөрүүдийн урсгал зардал

Тойм дүгнэлт

Тэрбум төгрөг



- Монгол улсын 2017 оны нэгдсэн төсөвт БСШУС-ын сайдын багц дахь боловсрол, шинжлэх ухааны хөтөлбөрүүдийн нийт урсгал зардлын хэмжээг **1065.5** тэрбум төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад **1.4%-иар** өсчээ.
- Үүнээс сургуулийн өмнөх боловсрол **26.5%**, ерөнхий боловсрол **56.9%**, дээд боловсрол **11.5%**, шинжлэх ухаан технологи **3.1%**, насан туршийн болон албан бус боловсрол **0.3%**, тусгай хэрэгцээт боловсрол **0.6%**, боловсрол, ШУ-ны бодлого, удирдлага **1.2%-ийг** тус тус зарцуулна.
- Өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад дээд боловсролын хөтөлбөрийн урсгал зардал **22.8%-иар** буурчээ.
- Нийт боловсрол, ШУ-ны хөтөлбөрийн урсгал зардлыг төрлөөр нь авч үзвэл цалин, НДШ **3.6%**, бараа үйлчилгээ **3.7%**, татаас шилжүүлэг **83.2%-ийг** тус тус эзэлж байна.


Эх үүсвэр: Сангийн яам

Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүд бага зэрэг сайжирч байна.


Суралцах хүүхдийн тоо




Хамран сургалтын хувь



Хүүхдийн цэцэрлэгийн тоо



Төрийн бус өмчийн цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо



Эх үүсвэр: БСШУСЯ, Сангийн яам

Ерөнхий боловсролын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)

Өөрчлөлт %

Хувийн жин %

Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	3100,9%		0.4%
Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	196,1%		0.4%
ЕБС-ийг сурах бичгээр хангах	190,5%	Зардал өсөх	0.8%
Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	13,8%		0.1%
Харуул хамгаалалтын зардал	11,1%		0.0%
Тусгай зориулалтын шилжүүлэг	5,6%		96.9%
Үндсэн үйл ажиллагааны зардал	4,2%		1.1%
Боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх	0,0%	Зардал өөрчлөгдөхгүй	0.2%
Олимпиад зохион байгуулах	0,0%		0.0%
Үдийн цай хөтөлбөр	0,0%		0.0%
Холбооны суваг ашигласны хөлс	0,0%		0.2%
	-2,2%	Дотуур байрны үйлчилгээ	0.0%
	-6,7%	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	0.0%
Зардал буурах	-100,0%	Биеийн тамирын уралдаан тэмцээн	0.0%
	-100,0%	Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, дэмжлэг	0.0%


Ерөнхий боловсролын хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх, ЕБС-ийг сурах бичгээр хангах зардал тус тус өссөн бол дотуур байрны үйлчилгээ, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, биеийн тамирын уралдаан тэмцээн, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Ерөнхий боловсролын хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардал нь тусгай зориулалтын шилжүүлэг 96.9% байна.

Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тооны өсөлт нь зардлын өсөлтөд нөлөөлж байна. Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоог бууруулна.

Ерөнхий боловсролын сургуулийн тоо




Дотуур байранд хамрагдах хүүхдийн тоо



Суралцах хүүхдийн тоо



Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо




Эх үүсвэр: БСШУСЯ, Сангийн яам

Дээд боловсролын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)

Өөрчлөлт %


Хувийн жин %




Дээд боловсролын хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөр, орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ЗГ-ын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг, оюутны сургалтын төлбөрийн зээлийн зардал тус тус өссөн бол үндэсний тэтгэлэг, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийн зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Дээд боловсролын хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардал нь оюутны сургалтын төлбөрийн зээл 73.5% байна.

Дээд боловсролын үр дүнгийн зарим үзүүлэлтүүд буурна. Багшлах дадлагад хамрагдах суралцагчийн тоог нэмэгдүүлнэ.


Их, дээд сургуулийн тоо




Багш, инженерийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах суралцагчийн тоо



Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо




Багшлах дадлагад хамрагдах суралцагчийн тоо





Эх үүсвэр: БСШУСЯ, Сангийн яам

Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)



Шинжлэх ухаан технологийн хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардал тус тус өссөн бол ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардлууд нь үндсэн үйл ажиллагааны зардал 61.9%, эрдэм шинжилгээ, судалгааны ажил 32% байна.

Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь буурна.



Эх үүсвэр: БСШУСЯ, Сангийн яам

Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлт (зориулалтаар)




Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагын хөтөлбөрийн зардлын өөрчлөлтийг зориулалт тус бүрээр авч үзвэл бүх шатны боловсролын мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээ, боловсролын заавар, журам, гарын авлага бэлтгэх, хэвлүүлэх зардал тус тус өссөн бол үндсэн үйл ажиллагаа, бусад зориулалт, арга хэмжээний зардал буурсан дүнтэй байна. Бусад зардлын зориулалтын хувьд 2016 оны тодотгосон төсвийн хэмжээтэй ижил байхаар тооцжээ. Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагын хөтөлбөрийн нийт зардалд хамгийн өндөр хувь эзэлж буй зардал нь, үндсэн үйл ажиллагааны зардал 89.3% байна.

2017 оны эрүүл мэнд ба БСШУС-ын сайдын төсвийн багцад хөрөнгийн зардал бага хувь эзэлж байна.

Эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалтад хөрөнгийн зардлын эзлэх хувь


Эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалтад хөрөнгийн зардал 5.2%-ийг эзэлж байна.



Эрүүл мэндийн сайдын хөрөнгийн зардалд нийт 34.3 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд үүний 67.9% буюу 23.3 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт, 8.7% буюу 3 тэрбум төгрөг нь их засвар, 23.3% буюу 8 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмжийн зардал байна.

БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтад хөрөнгийн зардлын эзлэх хувь

БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтад хөрөнгийн зардал 7.1%-ийг эзэлж байна.



БСШУС-ын сайдын хөрөнгийн зардалд нийт 97.2 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд үүний 83% буюу 80.7 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт, 5.7% буюу 5.6 тэрбум төгрөг нь их засвар, 11.3% буюу 11 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмжийн зардал байна.

Эх үүсвэр: Сангийн яам

2017 оны Эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалтын онцлог

- 1 Эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь дэлхийн бусад орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байна.
- 2 Эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд зарцуулах нийт урсгал зардлын хэмжээ өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад бага зэрэг өснө.
- 3 Нийт урсгал зардалд цалин хөлс ба боловсон хүчинтэй холбогдох зардал өндөр байна.
- 4 Орлогын ижил түвшинтэй орнуудтай харьцуулахад нярай ба бага насны хүүхдийн эндэгдэл харьцангуй бага байна.
- 5 Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн салбарын үр дүнгийн үзүүлэлтүүд төдийлэн өндөр ахицтай биш байна.
- 7 Эрүүл мэндийн үндэсний зарим хөтөлбөрүүдийн зардал буурна.
- 8 Эрүүл мэндийн сайдын багц дахь хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин бага байна.

2017 оны БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтын онцлог

- 1 БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувь дэлхийн бусад орнуудтай харьцуулахад боломжийн түвшинд байна
- 2 Нийт урсгал зардалд ерөнхий боловсролын хөтөлбөрийн зардлын эзлэх хувийн жин өндөр байгаа бөгөөд Ерөнхий боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал өснө.
- 3 Дээд боловсрол, насан туршийн албан бус боловсрол, боловсрол, ШУ-ны бодлого удирдлагын хөтөлбөрүүдийн урсгал зардлын хэмжээ буурна.
- 4 Сүүлийн жилүүдэд боловсролын салбарын үр дүнгийн үзүүлэлтүүд төдийлэн өндөр ахицтай биш байна.
- 5 Нийт урсгал зардалд татаас шилжүүлгийн эзлэх хувийн жин өндөр байна.
- 6 Дээд боловсролын үндэсний тэтгэлгийн зардлыг бууруулна.
- 8 БСШУС-ын сайдын багц дахь хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин бага байна.

Бодлогын зөвлөмж

- 1 Эрүүл мэндийн сайдын төсвийн зарцуулалтын ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлэх
- 2 Эрүүл мэнд, боловсролын салбарын зардлын хуваарилалтыг сайжруулах
- 3 Эрүүл мэнд, БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтын үр ашиг ба эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх
- 4 Эрүүл мэнд, БСШУС-ын сайдын төсвийн багц дахь хөрөнгийн зардлын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх
- 5 Эрүүл мэнд, БСШУС-ын сайдын төсвийн зарцуулалтад тавих хяналтыг нэмэгдүүлэх

ЭРҮҮЛ МЭНД БА БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ

Анхаарал тавьсанд баярлалаа!



Нээлттэй Нийгэм Форум
Бодлогын хэлэлцүүлэг

Холбоо барих:

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамъян гүний гудамж 5/1

Улаанбаатар 14240 Монгол Улс

Утас: 976-11313207

Факс: 976-11324857

email: osf@forum.mn